


Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн
297 дугаар тогтоолын 15 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн төв

Албан тушаалын нэр:

Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт, хавдрын бүртгэл мэдээлэл, ахмад настны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, Т3-5

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баян-Өлгий аймаг, Өлгий сум 11 дүгээр баг, төрх гудамж 113 байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого шийдвэрийн хүрээнд зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хавдрын бүртгэл хяналтын талаарх бодлого, үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах, ахмад настны эрүүл мэндийг хамгаалах, хүн амын дунд халдварт бус өвчин, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах, мэргэжил арга зүйгээр ханган, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн төвийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах арга хэмжээг зохион байгуулах, салбарын хоорондын оролцоог хангаж, лавлагаа, зөвлөмж мэдээллээр хангах.

2. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил болон эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний цогц тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагын оролцоонд түшиглэн бэхжүүлж, өвчлөл, нас баралтын тоог бууруулах нөхцөл бүрдүүлэх, ахмад настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх.

3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, осол гэмтэл, сэтгэцийн өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах талаар гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогыг хэрэгжүүлэх, тайлагнах;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.	Г,Х
	2.Халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;		Г,Х
	3.Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг судлах судалгааны ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, судалгааны дүнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэх, арга зүйгээр хангаж ажиллах;	Халдварт бус өвчний эрт илрүүлэлт сайжирч, иргэдийн хандлага дээшилсэн байна.	Г
	4.Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг жигд хүртээмжтэй тасралтгүй явуулахад шаардлагатай арга хэмжээг бусад холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулах;		Г
	5.Халдварт бус өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн чиглэлээр олон улсын байгууллагын		



	санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, үндэсний хөтөлбөр, стратегитай уялдуулах, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах;		Г
	6.Хэрэгжиж байгаа хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийн талаар мэдээллийн сан байгуулах, баяжуулах ажлыг зохион байгуулах;		Г
	7.Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах чиглэлээр мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах;	Нэгдсэн бодлого, чиглэлийг байна.	Г, Х
	8.Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах арга хэмжээг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад үр дүнтэй зохион байгуулахад мэргэшил аргазүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хяналт тавих.	Хэрэгжилт хангагдсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1 Халдварт бус өвчин түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шалтгаан нөхцөлд судалгаа тандалт хийх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх;	Судалгааны сантай болсон байна.	Г
	2.Халдварт бус өвчнөөс сэргийлэх талаар иргэд, олон нийтийн хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны ажилд арга зүйн дэмжлэг үзүүлэх;		Г
	3.Хүний нас, хүйс, амьдралын мөчлөгийн онцлогт тохируулан өвчнийг эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний жагсаалтыг баталж, хяналтад орсон иргэдийг бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд оруулах;	Арга зүйн зөвлөгөө өгч, салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирсан байна	Г,Х
	4.Хавдрын бүртгэл мэдээлэл, хүн амд суурилсан цусны даралт ихсэх, чихрийн шижингийн хэв шинж-2, умайн хүзүү, хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, тандах, хянах, эмчлэх одоогийн тогтолцоонд үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг		Г,Х



	хэрэгжүүлэх;		
	5.Ахмад настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлэн, тайлагнах;	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хангагдсан байна.	Г
	6.Ахмад настны амьдралын идэвхтэй хэв маягийг дээшлүүлж, нийгмийн дунд эрүүл, идэвхтэй амьдрах таатай орчин бүрдүүлэхэд эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;	Арга зүйн зөвлөгөө өгч, салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирсан байна	Г
	7.Ахмад настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах ажлын хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг харьяа байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгуулах, үр дүнг тайлагнах.	Арга зүйн зөвлөгөө өгч, салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирсан байна	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм журмыг хэрэгжүүлэх;	Ёс зүйн хэм хэмжээ зөрчөөгүй байна.	Г
	2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд хангагдсан байна.	Г
	3.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх, тайлагнах;		Г
	4.Удирдлагаас өгсөн болон хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх;	Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г
	5.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;		Г
	6.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.		Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	Анагаах ухаан /0912/, анагаах ухааны оношилгоо ба эмчилгээний



	технологи, уламжлалт анагаах ухаан /091701/.	
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачлагатай ажиллах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, зэрэг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй, шударга байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх, - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө

	<p>мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</p> <ul style="list-style-type: none"> - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.
--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <p>- Байхгүй.</p>	<p>Бусад харилцах субъект:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар. -Бага эмч, дотор, мэс засал, гэмтэл, сэтгэцийн эмч, сувилагч нар. -Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох ажилтан. -ЭМЯ-ны холбогдох мэргэжилтэн -Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн холбогдох мэргэжилтнүүд. -Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан.
---	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p><u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u></p>	<p><u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u></p>
<p><u>Албан тушаал:</u></p> <p>ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН</p> <p><i>[Signature]</i> Б.НУРЖАЙНАР</p> <p>20.19 оны 12 дугаар сарын 31-ны өдөр</p>	<p><u>Байгууллагын нэр:</u></p> <p>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> 19 11 04</p> <p><u>Дугаар:</u> 297</p>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо..... 2019.12.31.

Дугаар..... А/79

(тамга/тэмдэг)

ДАРГА..... *[Signature]* С.АЙГҮЛ

20.19 оны 12 дугаар сарын 31-ны өдөр

БЮЕ0019

